

## МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН 21 ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ, ӨРГӨН БАРИХ ЗОХИЦУУЛАЛТЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

(Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох нийцлийн хүрээнд)

### АСУУДЛЫН ТАНИЛЦУУЛГА

Хууль тогтоомж нь нийгмийн харилцааг зохицуулах зорилготой тул бодитой бөгөөд тогтвортой үйлчлэх чанартай байх шаардлага тавигддаг. Монгол Улс хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлж, хууль санаачлан боловсруулах, олон нийтийн оролцоог хангах болоод Улсын Их Хурал (УИХ)-д өргөн мэдүүлэх, баталсан хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх зэрэг үйл явцыг зохицуулсан Хууль тогтоомжийн тухай хуулийг 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж байна.

Өнгөрсөн 6 жилийн хугацаанд дээрх хуульд 4 удаа нэмэлт, өөрчлөлт оруулан шууд боловсруулж, батлах хууль тогтоомжийн жагсаалтыг өргөжүүлэн, 20 төрлийн хууль тогтоомжийн

төслийг хамруулаад байна. Ийнхүү хууль тогтоогч батлах хуулиа “хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал хамаарахгүй боловсруулах, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй байж болох”<sup>1</sup> хуулийн жагсаалтад тухай бүр нэмж, шууд боловсруулан баталж ирлээ.

Мөн сүүлийн жилүүдэд “үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах”-тай<sup>2</sup> холбоотой хэмээн яаралтай горимоор шууд боловсруулсан хуулийг өргөн барьж, баталж байна. Үүнээс гадна, Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж, өргөн барьдаг тухайн жилийн төсвийн тухай хуультай хамт олон тооны хуульд өөрчлөлт оруулах хууль баталдаг жишиг тогтов. Тухайлбал, 2018 оны төсвийн тухай хуультай

<sup>1</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг

<sup>2</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.17, 12.2.18 дахь заалтууд, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.18 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.1, 3.4.3 дахь заалтууд



Б.Наранцэцэг, Өмгөөллийн Фиделитас партнерс ХХН-ийн хамтран үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал

МУИС-ийн Хууль зүйн сургуулийг 2015 онд Эрх зүйн бакалавр, СЭЗИС-ийн Олон Улсын Нягтлан Бодох бүртгэлийн сургуулийг 2020 онд Бизнесийн удирдлагын бакалаврын зэрэгтэй тус тус төгссөн. Мэдээллийн технологи, Татвар, Хөрөнгө оруулалтын чиглэлд зөвлөх үйлчилгээ, Захиргааны маргаан, Эрүү (Кибер аюулгүй байдлын эсрэг, Эдийн засгийн болон Авлигын зарим гэмт хэрэг)-ийн хэрэгт өмгөөллийн үйлчилгээ дагнан үзүүлдэг.

хамт 3, 2019 оны төсвийн тухай хуультай хамт 10, 2020 оны төсвийн тухай хуультай хамт 14, тодотголтой хамт 22, 2021 оны төсвийн тухай хуультай хамт 10, тодотголтой хамт 4, 2022 оны төсвийн тухай хуультай хамт 30, хоёр удаагийн тодотголтой хамт 17, 2023 оны төсвийн тухай хуультай хамт 106, тодотголтой хамт 10 хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталжээ.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт 5 хуульд өөрчлөлт оруулах, 5 хуульд нэмэлт оруулах, 11 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу нийт 21 хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл өргөн мэдүүлэгджээ.<sup>3</sup> Иймд Төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн баригдсан эдгээр хуулийг шууд батлах нь Хууль тогтоомжийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн холбогдох зохицуулалтад нийцэх эсэхэд дүн шинжилгээ хийх шаардлагатай гэж үзлээ. Мөн тухайн жилийн төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлж байгаа хуулиудын

өөрчлөлтийг анхдагч хуулийн хэрэгжилтийн үр дагавартай холбож үнэлгээ хийхгүй, эсхүл өөрчлөлтийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлахгүй шууд тодорхойлж, зөвхөн Төсвийн тухай хуульд заасан хэлэлцүүлгийн үе шатнаас баталж байгаа хууль тогтоох үйл ажиллагаа дахь хууль хэрэглээний асуудлыг ч авч үзлээ.

Хууль тогтоомж нь нийгмийн харилцааны үндсэн зохицуулагч тул агуулга (нийгмийн бодит байдалд нийцэх чадвар) болон хэлбэр (хууль зүйн хэлбэр)-ийн хувьд нийгмийн харилцааг бодитой зохицуулах чанартай байх ёстой.<sup>4</sup> Чанартай хууль тогтвортой үйлчилдэг ба хууль боловсруулах болсон үндэслэлийг ул суурьтай тодорхойлж, боловсруулалтыг сайн хийснээр тогтвортой үйлчлэлийг бий болгоно. Хэтэрхий яаралтай, өнгөц хандлага, бодит байдлын буруу тусгал зэрэг нь хууль тогтоомжид олон удаа нэмэлт, өөрчлөлт оруулах байдалд хүргэх эрсдэлтэй.<sup>5</sup>

## **НЭГ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ҮЕ ШАТ, АРГАЧЛАЛ БАРИМТЛАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ӨӨРЧЛӨЛТҮҮД**

2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон Хууль тогтоомжийн тухай хуулийг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмаас гадна олон нийтийн оролцоог хангах,<sup>6</sup> судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх<sup>7</sup> зэрэг нийтлэг зарчмыг аливаа хуулийн төсөл боловсруулахад баримтлахаар хуульчилсан юм. Энэхүү хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын үе шат”-ыг эрэмбэлэхдээ эн тэргүүнд хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр заажээ. Эдгээр зохицуулалтыг

хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар 2016 оны 59 дүгээр тогтоолоор<sup>8</sup> “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” зэрэг 6 аргачлал батлан мөрдөж эхэлсэн байна. Гэвч нийт 3 удаагийн өөрчлөлтөөр 20 төрлийн хууль тогтоомжийн төслийг энэхүү хуульд хамруулахгүй болгожээ. Ийнхүү хууль тогтоомжийн төслийг судалгаа, шинжилгээнд үндэслэхгүй шууд боловсруулах зохицуулалтын агуулгыг өргөтгөж ирсэн нь хууль боловсруулах, ялангуяа санхүү, төсвийн үр нөлөөг урьдчилан тооцож, үр дагаврыг үнэлэх ажлын чанарт сөргөөр нөлөөлж байна.

<sup>3</sup> <https://d.parliament.mn/tusul/c559f76b-1884-44ec-b34e-ee9afbbb2fcc> (Хандсан огноо: 2023.10.20)

<sup>4</sup> Т.В.Кашанина, Хууль зүйн техник, УБ, 2016 он, 132 дахь тал

<sup>5</sup> Т.В.Кашанина, Хууль зүйн техник, УБ, 2016 он, 133 дахь тал

<sup>6</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт

<sup>7</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт

<sup>8</sup> Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр “Аргачлал батлах тухай” тогтоолоор баталсан.

## Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал баримтлахгүй байх талаарх 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өөрчлөлт

Хууль тогтоогч 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар<sup>9</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-12.1.6 дахь хэсэгт заасан аргачлал хамаарахгүй байх хуулийн төслийн дараах жагсаалтыг агуулсан 12.2 гэсэн хэсэг шинээр нэмжээ. Үүнд:

1. Гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээ;
2. Тухайн жилийн улсын төсөв, төсвийн тодотгол;
3. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл;
4. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр;
5. Засгийн газрын өрийн удирдлагын стратеги;
6. Улсын төсвийн гүйцэтгэл батлах тухай;
7. Дайны байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Дайн бүхий байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан УИХ-ын шийдвэрийн төсөл;
8. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хууль;
9. Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх;<sup>10</sup>
10. УИХ-ын дотоод зохион байгуулалт, УИХ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагааны тухай тогтоол болон УИХ-ын анхдугаар чуулганаар УИХ-ын дарга, дэд даргыг сонгох тухай УИХ-ын тогтоол;
11. Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төсөл батлах тухай;
12. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай;
13. Улсын эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай;

14. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай;
15. Төрөөс мөнгөний талаар тухайн жилд баримтлах үндсэн чиглэл батлах тухай;
16. Албан тушаалтныг томилох, чөлөөлөх тухай зэрэг багтжээ.

Мөн хуульд аргачлал хамаарахгүй боловсруулах дээрх хуулиудын төслийг боловсруулах үе шатад олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй байж болох “Энэ хуулийн 12.2-т заасан хууль тогтоомжийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй байж болно” гэсэн зохицуулалт нэмсэн байсныг 2023 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар “Хууль санаачлагчийн боловсруулж байгаа хууль тогтоомжийн төслийн хуулиар нууцад хамааруулсан асуудалтай холбоотой хэсгээр олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй” гэж өөрчлөн олон нийтийн хэлэлцүүлэг хийх хуулийн төслийн хүрээг тэлсэн байна.<sup>11</sup>

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулийн төслийн үзэл баримтлалд тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан Засгийн газраас боловсруулж, УИХ-аас яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөл, Олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төсвийн гүйцэтгэл, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, төрөөс мөнгөний талаар тухайн жилд баримтлах бодлого батлах УИХ-ын тогтоолын төсөл зэрэг хууль тогтоомжийн

<sup>9</sup> Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль (<https://legalinfo.mn/mn/detail?lawId=103078&show-Type=1>)

<sup>10</sup> Тус хэсгийг Хууль тогтоомжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар “Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох, чөлөөлөх” гэж өөрчилсөн.

<sup>11</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг

төслийг боловсруулахад Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасан аргачлал хамаарахгүй байхаар зохицуулах, цаашилбал, төсөвт холбогдох харилцааг Төсвийн тухай хуулиар зохицуулах нь зүйтэй гэж дүгнэсэн байдаг.<sup>12</sup>

Дээрх хуулийн үзэл баримтлалд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох болон эдийн

засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл нь бодлого, төлөвлөлтийн шинжтэй баримт бичиг тул тэдгээрт тусгасан хууль тогтоомжийн төсөл боловсруулахад холбогдох аргачлалын дагуу үнэлгээ хийх талаар дурджээ. Ийнхүү хууль бүтээх үйл явцдаа судалгаа, шинжилгээний үе шатыг алгасан баталж болох хууль тогтоомжийн хүрээг өргөтгөсөн байна.<sup>13</sup>

### **Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал баримтлахгүй байх талаарх 2017 оны 5 дугаар сарын 12-ны өөрчлөлт**

Хууль тогтоогчоос 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар<sup>14</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-12.1.6 дахь хэсгүүдэд заасан аргачлал хамаарахгүй буюу шууд боловсруулж, батлах хууль тогтоомжийн жагсаалтыг улам өргөжүүлсэн дараах нэмэлтийг хийжээ. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16.1.1-д заасан хууль тогтоомжийн төсөл;
2. Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.1 дэх заалт (Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал), 3.4.3 дахь заалт (иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй

байдал)-ын асуудлаар боловсруулсан хууль тогтоомжийн төсөл;

3. Дипломат харилцаа тогтоох тухай;
4. Дипломат төлөөлөгчийн газрын түвшин, байршлыг тогтоох тухай;
5. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч батлах тухай;
6. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай;
7. Онцгой албан татвар ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөх тухай УИХ-ын шийдвэрийн төсөл;
8. Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулахаар боловсруулсан хууль тогтоомжийн төсөл зэрэг болно.

### **Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал баримтлахгүй байх талаарх 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өөрчлөлт**

Хууль тогтоогч 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар<sup>15</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-12.1.6 дахь хэсэгт заасан аргачлал

хамаарахгүй шууд боловсруулж, батлах хууль тогтоомжийн жагсаалтад “Монгол Улсын Их Хурлын тухай болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай” гэж нэмжээ.

<sup>12</sup> Хууль зүйн сайд Д.Дорлигжавын баталсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн төслийн үзэл баримтлал /шинэчилсэн найруулга/-ыг Монгол Улсын Их Хурлын тамгын газрын архиваас цаасаар гаргуулж танилцав.

<sup>13</sup> Б.Баялагмаа нар “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх үе шатад хийсэн дүн шинжилгээ” судалгааны тайлан, УБ.,2022 он, 13 дахь тал.

<sup>14</sup> Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2017 оны 5 дугаар сар (<https://legalinfo.mn/mn/detail?lawId=103084&showType=1>)

<sup>15</sup> Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2020 оны 4 дүгээр сар (<https://legalinfo.mn/mn/detail?lawId=103722&showType=1>)

Хууль тогтоогчоос 2023 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар<sup>16</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааг анхдагч хуулийн төсөл болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зарчмын шинжтэй зохицуулалт шинээр нэмж оруулж

*байгаа хуулийн төслийг боловсруулахад хийнэ” гэж нэмсэн байна.*

Ингэснээр, Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т жагсаалтад хамаарахгүй хуулийн төслийг боловсруулахад “хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах” аргачлалыг заавал баримтлах агуулгыг сулруулсан байна.

## **ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГАД ТАВИГДАХ ЗОХИЦУУЛАЛТЫН НИЙЦЭЛ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд хуулийн төслийн үзэл баримтлал боловсруулж, баталгаажуулах журам, 33 дугаар зүйлд хуулийн төслийн танилцуулгын агуулгыг тус тус зохицуулсан байна. Мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын нэгдүгээр бүлэгт Хуулийн төслийн үзэл баримтлал боловсруулах, хоёрдугаар бүлгийн 7-д Хуулийн төслийн танилцуулга боловсруулах аргачлалыг тусгажээ. Эдгээр зохицуулалт хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлд адил хамаарах тул дараах зохицуулалтыг хамруулан нийцлийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэлээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, эсхүл анхдагч хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнд үндэслэн үзэл баримтлалын төсөл боловсруулахаар заасан байдаг. Тиймээс Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал хамаарахгүй байхаар тухайлан заасан хуулийн

төслөөс бусад хуулийн төслийг боловсруулах, үзэл баримтлалыг нь тодорхойлоход хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, эсхүл анхдагч хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ заавал шаардагдана. Харин Улсын төсөв, төсвийн тодотгол<sup>17</sup>, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл<sup>18</sup> болон Улсын төсвийн гүйцэтгэл<sup>19</sup> батлах хуулийн төсөл боловсруулахад хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал хамаарахгүй байхаар хуульчилсан. Тодруулбал, Тухайн жилийн төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа шаардахгүй.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.5 дахь хэсгүүдэд тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн төслийг нэгэн зэрэг хамтад нь хэлэлцүүлэхээр багцлан боловсруулахдаа тухайн харилцааг зохицуулж байгаа ерөнхий хуулийг дагаж анхдагч хуулийн төсөл боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд төсөл тус бүрийн агуулгыг нэгтгэн нэг үзэл баримтлалаар тодорхойлж болохоор хуульчилсан

<sup>16</sup> Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2023 оны 5 дугаар сар (<https://legalinfo.mn/detail?lawId=16759308715161&showType=1>)

<sup>17</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2 дахь заалт

<sup>18</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3 дахь заалт

<sup>19</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.6 дахь заалт

байдаг. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн 21 хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн

үзэл баримтлалыг нэгтгэн боловсруулсан нь дээрх зохицуулалтад нийцэж байна.

## 2.1. Үзэл баримтлалын агуулгыг тодорхойлсон зохицуулалтын нийцэл

Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 дахь хэсэг, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын нэгдүгээр бүлгийн 3 дахь хэсэгт хуулийн төслийн үзэл баримтлалын агуулгад тавих шаардлагуудыг тодорхойлсон байдаг. Монгол Улсын 2024 оны

төсвийн тухай хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн 21 хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын нэгтгэсэн боловсруулалтад эдгээр шаардлагыг баримталсан эсэхэд дүн шинжилгээ хийлээ.

*Хүснэгт 1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын агуулгад тавигдах шаардлагад нийцсэн эсэх харьцуулалт*

	Хуульд тодорхойлсон шаардлага	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал
1	Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага тодорхой тайлбарлаж тусгах	Үзэл баримтлалын 1 дүгээрт Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл, шаардлагыг дурдсан ч хамт өргөн мэдүүлсэн 21 хуулийн төсөлд өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлага болон үзэл баримтлалыг нэгтгэн боловсруулах, хамт өргөн мэдүүлэх хууль зүйн үндэслэлийг дурдаагүй.
2	Хуулийн төсөл нь хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарт нийцэж байгаа эсэхийг үндэслэл, шаардлагад тодруулна. <sup>20</sup>	Үзэл баримтлалд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 21 хуулийн төсөл нь санаачлах эрхийн хүрээ, хязгаарыг тогтоосон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлд нийцэж байгааг нотолсон үндэслэл, шаардлагыг дурдаагүй.
3	Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ	Үзэл баримтлалын 2 дугаарт Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг бүлэг тус бүрээр нь тодорхойлсон ч хамт өргөн мэдүүлсэн 21 хуулийн төслийн зорилго, өөрчлөлтийн хамрах хүрээ, зохицуулах харилцааг дурдаагүй.
4	Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдаж	Үзэл баримтлалын 4 дүгээрт Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ гэжээ. Гэвч ийнхүү дүгнэсэн үндэслэл тодорхойгүй, ялангуяа хамт өргөн мэдүүлсэн 21 хуулийн төслийн өөрчлөлт бусад хуультай хэрхэн уялдаж буйг Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын нэгдүгээр бүлгийн 3.5.1-3.5.2 тодорхойлсон агуулгаар тусгаагүй.
5	Хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал	Үзэл баримтлалын 4 дүгээрт Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 21 хуулийн төсөл, УИХ-ын 7 тогтоолын төслийг дурдсан байна. Ийнхүү нэр жагсаахдаа Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын нэгдүгээр бүлгийн 3.5.3-д хуулийн төсөлтэй уялдуулан нийцүүлэх зорилгоор ямар хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, ямар хуулийг хүчингүй болгох шаардлагатай байгааг судалж, тодорхойлсон агуулга тусгаагүй.

<sup>20</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг

	Хуульд тодорхойлсон шаардлага	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал
6	Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал	Үзэл баримтлалын 3 дугаарт Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл батлагдсанаар Засгийн газрын үйл ажиллагааны 2024 оны хөтөлбөр, хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ гэж л дурджээ. Улмаар, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 21 хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох үр дагаврыг Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын нэгдүгээр бүлгийн 3.4.2-3.4.5-д зааснаар тодорхойлоогүй.

Үзэл баримтлалд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан нийцүүлэх ямар хэрэгцээ, шаардлага үүссэний

улмаас 21 хуульд өөрчлөлт оруулах төсөл боловсруулах болсон тухай агуулга тусгаагүй байна.

## 2.2. Хуулийн төслийн танилцуулгын агуулгыг тодорхойлсон зохицуулалтын нийцэл

Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын хоёрдугаар бүлгийн 7-д хуулийн

төслийн товч болон дэлгэрэнгүй танилцуулгын агуулгыг тодорхойлсон байдаг (Хүснэгт 2).

### Хүснэгт 2. Хуулийн төслийн танилцуулгын агуулгад тавигдах шаардлага

Товч танилцуулга <sup>21</sup>	Дэлгэрэнгүй танилцуулга <sup>22</sup>
<ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, хуулийн төсөлд тусгасан зарчмын шинжтэй зохицуулалтын талаар;</li> <li>- Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал;</li> <li>- Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;</li> <li>- Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн;</li> <li>- Гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлт.</li> </ul>	<p>Хуулийн төсөл болон дагаж гарах хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрд дараах мэдээллийг агуулсан тайлбарыг тусгана:</p> <ul style="list-style-type: none"> <li>- нэмэлт, өөрчлөлт оруулах, өөрчлөн найруулах, үг, өгүүлбэрийг хасах, хүчингүй болсонд тооцох болсон үндэслэл, шаардлага;</li> <li>- зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалтыг хэрхэн ойлгох тухай;</li> <li>- нэр томьёо, ухагдахууны үүсэл.</li> </ul>

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын хоёрдугаар бүлгийн 7.3, 7.4 дахь хэсгүүдэд дараах асуудлыг зохицуулсан бөгөөд үүнд:

- Танилцуулгад тухайн төсөлд тусгасан зарчмын шинэлэг зохицуулалтыг хийх болсон шалтгаан нөхцөл, хийсэн хэлбэр, хэмжээг дэлгэрэнгүй тайлбарлах;

- Хуулийн төслийн танилцуулга хуулийн төслийн үзэл баримтлалыг хуулбарлан давхардуулж бичих, хамаарахгүй асуудлыг оруулах, хэт нурших алдаанаас зайлсхийх гэжээ.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн 21 хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгыг дээрх зохицуулалтын дагуу бэлтгээгүй байна. Тухайлбал:

<sup>21</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг

<sup>22</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3, 33.4 дэх заалтууд

- 21 хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрийн үндэслэл, шаардлагыг тусгаагүй;
- 21 хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалтыг хэрхэн ойлгох тайлбар тусгаагүй байна.

## ГУРАВ. ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮНДЭСЛЭЛ, БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

### 3.1. Хуулийн төслийн төрөл, тэдгээрийг боловсруулах тохиолдол болон аргачлалын зохицуулалт

Хууль тогтоомжийн тухай хууль (ХТТХ) аргачлалд хуулийн төслийн 4 төрөл, тэдгээрийг болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах боловсруулах тохиолдлыг ялгаатай зохицуулжээ.

*Хүснэгт 3. Хуулийн төслийн төрөл, тэдгээрийг боловсруулах ажлын үе шат, аргачлалын ялгаа*

	Хуулийн төслийн төрөл	Хуулийн төсөл боловсруулах тохиолдол	Хуулийн төсөл боловсруулах ажлын үе шат, аргачлал <sup>23</sup>
1	Анхдагч хуулийн төсөл (ХТТХ 22.1.1, 23.1)	Дараах тохиолдолд боловсруулна: - Шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах; - Тухайн харилцааны зохицуулалтыг шинэ хуулиар зохицуулах шаардлагатай болсон.	Тухайн хуулийн хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалгаа заавал хийнэ. <sup>24</sup>
2	Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл (ХТТХ 22.1.2, 24.1, 24.5) - Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай - Хуульд нэмэлт оруулах тухай - Хуульд өөрчлөлт оруулах тухай - Хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай	Дараах тохиолдолд боловсруулна: - Хуульд нэмэлт оруулах, хуулийн зарим зүйл, заалтыг өөрчлөн найруулах; - Тодорхой зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох.	Дараах тохиолдолд хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалгаа шаардахгүй <sup>25</sup> : - Анхдагч хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр өөрчлөлт оруулах зөвлөмж гарсан. <sup>26</sup>
		Хуульд зарчмын шинжтэй зохицуулалт шинээр нэмж оруулах тохиолдолд	Тухайн хуулийн хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалгаа заавал хийнэ. <sup>27</sup>
		Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулах тохиолдолд	Хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалгаа шаардахгүй. <sup>28</sup>
3	Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (ХТТХ 22.1.3, 25.1)	Дараах тохиолдолд боловсруулна: - өмнө нь тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нь нэмэлт, өөрчлөлт орсон; - хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас хуулийн бүтэц, уялдаа алдагдахад хүрэх, эсхүл тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох;	Дараахаас бусад тохиолдолд хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалгаа заавал хийнэ: Анхдагч хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр шинэчлэн найруулах зөвлөмж гарсан. <sup>29</sup>

<sup>23</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т заасан хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын үе шат, 12 дугаар зүйлийн 12.1-т заасан хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал баримтлах эсэхийг оруулав.

<sup>24</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг

<sup>25</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг

<sup>26</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.3 дахь заалт

<sup>27</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг

<sup>28</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.24 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг

<sup>29</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.3 дахь заалт



	Хуулийн төслийн төрөл	Хуулийн төсөл боловсруулах тохиолдол	Хуулийн төсөл боловсруулах ажлын үе шат, аргачлал <sup>23</sup>
		<ul style="list-style-type: none"> <li>- хуулийн үзэл баримтлалыг бүхэлд нь өөрчлөхөд хүргэсэн нэмэлт, өөрчлөлт орох;</li> <li>- тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон.</li> </ul>	
4	Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл (ХТХ 22.1.5, 261)	<p>Дараах тохиолдолд боловсруулна:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн шинэчилсэн найруулга батлахад анхдагч хуулийг хүчингүй болгох;</li> <li>- Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийг хүчингүй болгох.</li> </ul>	Анхдагч хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр хүчингүй болгох зөвлөмж гарсан тохиолдолд хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалгаа шаардахгүй. <sup>30</sup>

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлаагүй, мөн анхдагч хуулийн

хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгүйгээр 21 хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл өргөн мэдүүлсэн байна.

*Хүснэгт 4. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 21 хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн төрөл*

Хуулийн төслийн төрөл	Хуулийн төслийн нэр
Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслүүд	Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-д өөрчлөлт оруулах тухай
	Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
	Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
	Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай
Хуульд нэмэлт оруулах хуулийн төслүүд	Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай
	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай
	Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай
	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай
Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүд	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай
	Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
	Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
	Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
	Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
	Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
	Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

<sup>30</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.3 дахь заалт

### 3.2. Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн шаардлагын зохицуулалтын нийцэл

Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн агуулга, түүнийг боловсруулахтай холбоотой асуудлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 дэх заалт, 29.3, 29.4 дэх хэсгүүд, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын Хоёрдугаар бүлгийн 2.5, Дөрөвдүгээр бүлгийн 1.1-д хуульд өөрчлөлт оруулах тухай дараах байдлаар зохицуулжээ. Үүнд:

- Хуульд оруулах өөрчлөлт нь бодлого, үзэл баримтлал, хуулийн хэлбэр, техник, хэлзүйн хувьд анхдагч хуулийн үзэл баримтлал, хэлбэр, агуулгад нийцсэн байх;
- Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;
- Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль

хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулах гэжээ.

Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах шаардлагыг Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дөрөвдүгээр бүлгийн 1.2-т “хуульд оруулах өөрчлөлт хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуультай зөрчилдөх” тохиолдолд хуулийн төсөлд нийцүүлэн тэдгээр хууль тус бүрд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, тухайн хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлнэ гэж тодорхойлсон байдаг. Хуульд өөрчлөлт оруулах дээрх зохицуулалтад Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 21 хуульд оруулахаар боловсруулсан өөрчлөлтийн агуулга хэр нийцэж байгаад дүн шинжилгээ хийлээ.

### Төсвийн тухай хуульд тухайн жилийн төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлэхээр нэрлэн заасан хуулийн төслүүд

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын гуравдугаар бүлгийн 5.4-д тухай жилийн төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага, ажлын зохион байгуулалтыг Төсвийн тухай хуулийн тавдугаар бүлэгт зааснаар зохицуулахаар тусгасан байдаг.

Төсвийн тухай хуулийн Тавдугаар бүлэгт буюу 32 дугаар зүйлийн 32.1-т Засгийн газар дараах төсвийг тухайн жилийн төсвийн төслийн танилцуулгын хамт өргөн мэдүүлэхээр хуульчилсан бөгөөд үүнд:

- Улсын төсөв;
- Ирээдүйн өв сангийн төсөв;
- Нийгмийн даатгалын сангийн төсөв;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв багтана.

Тиймээс жил бүрийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт дээрх сангуудын тухайн жилийн төсвийн тухай хуулийг шинээр боловсруулан баталж ирсэн байна. Эдгээр хууль нь агуулгын хувьд улсын төсвийн тухайн жилийн орлого, зарлагатай уялдаатай байх, мөн Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-т ийнхүү хамт өргөн мэдүүлэхээр хуульчлагдсан юм.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 21 хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслөөс Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-т хамаарах хуулийн төсөл байгаагүй болно.

## Газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлаар нэмэхтэй холбоотой өөрчлөлт оруулах хуулийн төслүүд

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн “Нийслэл Улаанбаатар хотод гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, Нийслэлийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 294 тоот тогтоолын 1.2-т “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллуулах, ... асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт УИХ-д өргөн мэдүүлэх арга хэмжээ авахыг

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Сангийн сайд Б.Жавхлан нарт үүрэг болгосон” байна.<sup>31</sup>

Улмаар Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт дээрх асуудлын зохицуулалттай холбоотой 6 хуулийн төсөл боловсруулж өргөн мэдүүлсэн бөгөөд эдгээр хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь 2024 оны төсвийн тухай хуулийн орлого, зарлагад шууд нөлөөтэй гэхээс илүү зохион байгуулалт, эрх мэдлийн хуваарилалтыг өөрчлөх агуулгатай байна (Хүснэгт 5).

### Хүснэгт 5. Газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлаар нэмэхтэй холбоотой хуулийн төслүүд

Хуулийн төслүүд	Нэмсэн зохицуулалтын агуулга
Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Тус хуулийн 1 хэсэгт агуулга нэмэх, 2 хэсгээс агуулга хасах төсөл боловсруулсан бөгөөд эдгээр нь: <ul style="list-style-type: none"> <li>- Ерөнхий сайдын эрхлэх асуудлын жагсаалтад “газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал” гэж нэмсэн;</li> <li>- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлаас “газар зохион байгуулалт” гэснийг хасах;</li> <li>- Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлаас “газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал” гэснийг хасах зэрэг болно.</li> </ul>
Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Тус хуульд 3 заалт нэмж, 22 заалтыг өөрчлөн найруулж, 14 хэсгийг хасаж, 1 хэсгийг хүчингүй болсонд тооцох төсөл боловсруулсан бөгөөд эдгээр нь: <ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын газрын харилцааны талаар хэрэгжүүлэх бүрэн эрхэд “газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журмыг батлах”; “газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмыг батлах”; “улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар гаргасан газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлтэд үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгох шийдвэр гаргах ” гэж нэмэх зэрэг болно.</li> </ul>
Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Тус хуулийн 1 бүлэг, түүний 1 хэсгийн гарчигт өөрчлөлт оруулах төсөл боловсруулсан бөгөөд эдгээр нь : <ul style="list-style-type: none"> <li>- Кадастрын үйл ажиллагаатай холбоотой бүрэн эрх хэрэгжүүлдэг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “төв” гэснийг хасах зэрэг болно.</li> </ul>

<sup>31</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760201938501>

Хуулийн төслүүд	Нэмсэн зохицуулалтын агуулга
Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	<p>Тус хуулийн 1 хэсэгт өөрчлөлт оруулах төсөл боловсруулсан. Тухайлбал:</p> <p>- Газрын мэдээлэл, суурь үнэлгээ, төлбөр төлөгч, төлбөрийн хувь хэмжээ, ногдуулалт, төлөлт зэрэг мэдээлэл солилцох журмыг газрын төлбөрийн болон татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дарга хамтран батлахаар байсныг "асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай" гэж өөрчлөх</p>
Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	<p>Тус хуульд 5 заалт нэмж, 2 хэсэг, 2 заалтаас үг хасаж, 1 хэсгийг хүчингүй болсонд тооцох төсөл боловсруулсан бөгөөд эдгээр нь:</p> <p>- Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хэрэгжүүлэх чиг үүрэгт "геодези, зураг зүйн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах";" Монгол Улсын нутаг дэвсгэрийг зурагжуулах төрийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх";" геодези, зураг зүйн заавар, дүрэм батлах, стандартыг боловсруулж мөрдүүлэх";" олон улсын гэрээгээр геодези, зураг зүйн асуудлаар Монгол Улсын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах";" иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох" гэж нэмэх зэрэг болно.</p>
Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	<p>Тус хуульд 4 хэсэгт үг нэмж, 1 хэсэгт өөрчлөлт оруулж, 3 хэсгээс үг хасах төсөл боловсруулсан бөгөөд эдгээр нь:</p> <p>i. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэй эрхлэх ба тусгай зөвшөөрлийг Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгохоор байснаас "төв" гэснийг хасах;</p> <p>ii. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа явуулах мэргэжлийн байгууллагын эрх олгох үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхлэх ба тусгай зөвшөөрлийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгохоор байснаас "төв" гэснийг хасах;</p> <p>iii. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр Газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхлэх ба тусгай зөвшөөрлийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгохоор байснаас "төв" гэснийг хасах зэрэг болно.</p>

Дээрх төслүүд нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуультай шууд холбоогүй, харин Газрын тухай хуульд газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудал байхаар нэмсэн өөрчлөлттэй бусад хуулийг нийцүүлэх зорилгоор боловсруулагджээ. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Засгийн газрын хуульд нэмсэн агуулга нь зарчмын шинжтэй өөрчлөлт бөгөөд тухайн хуулийн хувьд шинэ агуулга болсон тул дээр дурдсан бусад 5 хуульд өөрчлөлт оруулах шаардлага үүсжээ.

Уг нэмсэн агуулга нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуультай нийцлийг хангах зорилгоор хамтад нь хуулийн өөрчлөлт

боловсруулах, зайлшгүй шаардлагатай өөрчлөлт хийх хэрэгцээг бий болгоогүй, харин улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар гаргасан газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлтэд үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгох шийдвэр гаргах эрхийг Ерөнхий сайдад олгосон, газартай холбоотой харилцаанд шийдвэр гаргах эрх хэмжээ, бүтэц, зохион байгуулалтыг бүхэлд нь өөрчилсөн шинжтэй хуулийн өөрчлөлт байгаа ажээ.

## Татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой өөрчлөлт оруулах хуулийн төслүүд

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон татвар ногдох орлогыг тодорхойлох, тайлагнахтай холбоотой дараах 5 хуулийн төслийг боловсруулж өргөн мэдүүлсэн байна (Хүснэгт 6).

### Хүснэгт 6. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон татвар ногдох орлогыг тодорхойлох, тайлагнахтай холбоотой хуулийн төслүүд

Хуулийн төслүүд	Нэмсэн зохицуулалтын агуулга
Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	<p>Тус хуульд 1 заалт нэмэх төсөл боловсруулсан бөгөөд энэ нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- НӨАТ-аас чөлөөлөх барааны жагсаалтад “малчин, мал бүхий этгээдийн борлуулсан таван хошуу мал, анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, арьс шир, ноолуур, хонь болон тэмээний ноос, сарлагийн хөөвөр” гэж нэмсэн болно.</li> </ul>
Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	<p>Тус хуулийн 1 хэсэгт үг нэмэх, 2 хэсгийг өөрчлөн найруулах төсөл боловсруулсан бөгөөд эдгээр нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Татварын алба мал тооллогын тоонд үндэслэн төлбөл зохих татварыг тодорхойлохоор нэмэх;</li> <li>- Татварын алба төлбөл зохих татварыг дараагийн татварын жилийн эхний улиралд багтаан татвар төлөгчид мэдэгдэх, ийнхүү татвар ногдуулах, төлөх журмыг Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батлахаар өөрчлөн найруулсан зэрэг болно.</li> </ul>
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	<p>Тус хуульд 3 хэсэг, 4 заалт нэмэх, 1 хэсэг, 1 заалт өөрчлөн найруулах төсөл боловсруулсан бөгөөд эдгээр нь:</p> <p><b>Татвар ногдох орлогыг тодорхойлоход:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- “Засгийн газар, аймаг, нийслэл, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаасыг Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг худалдаж авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэлийн дүнг хасаж, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно” гэж нэмэх;</li> <li>- “Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан Засгийн газар, аймаг, нийслэл, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаасыг борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох, суутган тооцох, төсөвт төлөх, тайлагнах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга хамтран батална.” гэж нэмэх;</li> </ul> <p><b>Татварын хөнгөлөлт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- “Орон нутагт шинээр барьсан нийтийн зориулалттай орон сууц борлуулсны орлогод ногдох албан татварыг нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг, Дархан-Уул болон Орхон аймгийн төвийн сумын хилийн цэс дотор 2024-2026 онд 50 хувиар, 2027-2029 онд 20 хувиар, эдгээрээс бусад аймаг, сумын хилийн цэсийн дотор 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар тус тус хөнгөлнө” гэж нэмэх;</li> <li>- “Нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг болон аймаг, сумын хилийн цэсийн дотор баригдсан нийтийн зориулалттай орон сууцны барилгад хүн амьдран суух зориулалтаар орон сууц түрээслүүлсний орлогод ногдох албан татварыг 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар тус тус хөнгөлнө” гэж нэмэх;</li> <li>- “Засгийн газар, аймаг, нийслэл, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн дотоодын үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар тус тус хөнгөлнө” гэж нэмэх;</li> </ul>

Хуулийн төслүүд	Нэмсэн зохицуулалтын агуулга
	<ul style="list-style-type: none"> <li>- “Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан Засгийн газар, аймаг, нийслэл, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод ногдуулах албан татварыг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон кастодиан ногдуулж, суутгана” гэж нэмэх зэрэг болно.</li> </ul>
<p>Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p>	<p><i>Тус хуульд 5 хэсэг нэмэх, 2 хэсэг, 2 заалт өөрчлөх, 2 хэсгийг хасах төсөл боловсруулсан бөгөөд эдгээр нь:</i>  <i>Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийн Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод албан татвар ногдуулах орлого тодорхойлох хэсэгт:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- “Засгийн газар, аймаг, нийслэл, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаасыг Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг” худалдан авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдох бусад зардлыг хассан дүнгээр албан татвар ногдуулах орлого тодорхойлохоор нэмэх;</li> <li>- “Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан Засгийн газар, аймаг, нийслэл, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох, суутган тооцох, төсөвт төлөхөд” Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэхээр хамт өргөн мэдүүлсэн дагуу Засгийн газрын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтран баталсан журмын дагуу тайлагнаж, төлөхөөр нэмэх;</li> </ul> <p><b>Албан татварын хөнгөлөлт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- “Нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг болон аймаг, сумын хилийн цэсийн дотор баригдсан нийтийн зориулалттай орон сууцны барилгад хүн амьдран суух зориулалтаар орон сууц түрээслүүлсний орлогод ногдох албан татварыг 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар тус тус хөнгөлнө” гэж, “Засгийн газар, аймаг, нийслэл, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар тус тус хөнгөлнө” гэж нэмэх;</li> </ul> <p><b>Татвар ногдуулж, суутгах журам:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- “Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээл Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон кастодиан ногдуулж, суутгана” гэж нэмэх зэрэг болно.</li> </ul>
<p>Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль</p>	<p><i>Тус хуульд 1 заалт, 1 хэсэг нэмэх, 3 хэсгийн дугаарлалт өөрчлөх төсөл боловсруулсан бөгөөд эдгээр нь:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Гаалийн татвараас чөлөөлөгдөх барааны жагсаалтад “төслийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмж” гэж нэмэх;</li> <li>- Гаалийн болон бусад татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлөх журамд “Ашигт малтмал баяжуулах, боловсруулах замаар нэмүү өртөг шингэсэн ашигт малтмалын баяжмал, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх техник, эдийн засгийн үндэслэл бүхий үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийн нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 4жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг Засгийн газар гаргаж болно” гэж өөрчлөх зэрэг болно.</li> </ul>

Дээрх өөрчлөлтүүд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн орлого, зарлагатай хэрхэн уялдаж байгаа нь хуулийн төслийн баримт бичгээс тодорхойгүй байна. Тухайлсан татварын харилцааг зохицуулж буй хуулиудад татвар ногдох орлогыг тодорхойлох, тайлагнах, төлөх журмыг өөрчлөх, тэдгээрийг хуулиас тусдаа журмаар баглах зохицуулалтын өөрчлөлт нь тухайн хуулийн хувьд зарчмын шинжтэй өөрчлөлт, шинэ агуулга болно. Нөгөөтэйгүүр, Монгол улс Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ийн Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг байгууллага (BEPS)<sup>32</sup>-ын гишүүн орны хувьд хүлээсэн үүргийг хэрэгжүүлж, татварын суурийг багасгах өөрчлөлтөд судалгаатай хандах шаардлагатай.

Татварын ил тод байдлыг хангах зорилгоор BEPS-ээс татварын хөнгөлөлттэй дэглэмийг дараах үндсэн гурван асуудлыг хамруулан үнэлдэг бөгөөд үүнд:

- Татварын хөнгөлөлттэй дэглэмийн үнэлгээгээр татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх, улмаар бусад улс орны татварын суурьд сөргөөр нөлөөлөхүйц татварын дэглэмийг тодорхойлох;
- Татвар төлөгчийн тусгайлсан татварын үнэлгээний талаарх холбогдох мэдээллийг заавал солилцох замаар Тавдугаар багц дүрмийн ил тод байдлын хамрах хүрээ, нөхцөлд хяналт шалгалт хийх;

## **ДӨРӨВ. ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТАТВАР ЗЭРЭГ БИЗНЕСИЙН ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ОНЦЛОГ ЗОХИЦУУЛАЛТЫН НИЙЦЭЛ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38, 39 дүгээр зүйлд хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах нийтлэг журмыг тодорхойлсон нь Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд мөн хамаарах зохицуулалт юм.

- Адил тэгш өрсөлдөөний нөхцөлийг хангахын тулд зөвхөн нэрлэсэн татвар (nominal tax)-ын харьяалалгүй эсвэл дангаараа үйл ажиллагаа явуулахад тавигдах шаардлагуудыг хянах зэрэг багтана.

Европын холбоо татварын ил тод байдлыг хангах, татвараас зайлсхийхийн эсрэг олон улсын дүрэм, журмыг хэрэгжүүлэх, холбогдох олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэж орох амлалт өгөөгүй гэх шалтгаанаар 2017 оны 12 дугаар сард Монгол Улсыг Татварын зорилгоор хамтран ажилладаггүй улс орнуудын жагсаалтад оруулж байсан. Тус жагсаалтаас гарах зорилгоор OECD-ын Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг байгууллага (Inclusive framework on base erosion and profit shifting) болон Татварын зорилгоор ил тод байдал, мэдээлэл солилцооны олон улсын форум (Global forum on transparency and exchange of information for tax purposes)-д Монгол Улс 2018 онд гишүүнээр нэгдэн орж, тодорхой үүрэг амлалтууд хүлээн, холбогдох шаардлага, стандартуудыг Татварын багц хуулийн шинэчилсэн найруулгад тусгаснаар 2020 оны 1 дүгээр сард жагсаалтаас гарч байсан юм.<sup>33</sup>

Тиймээс татвараас чөлөөлөх, хөнгөлөх хуулийн төслийг батлахдаа Монгол Улсыг татварын суурийг багасгаж, Европын холбооны Татварын зорилгоор хамтран ажилладаггүй улс орнуудын жагсаалтад орж байсантай ижил үндэслэл бүрдэх эсэхийг тухайлан судлах шаардлагатай.

Харин тухай жилийн төсвийн тухай хуулийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах асуудлыг Төсвийн тухай хуулийн 281 дугаар зүйлээр зохицуулж байна (Хүснэгт 7).

<sup>32</sup> Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг байгууллага (Inclusive framework on base erosion and profit shifting), <https://www.oecd.org/tax/beps/inclusive-framework-on-beps-composition.pdf>

<sup>33</sup> <https://www.consilium.europa.eu/en/press/press-releases/2020/10/06/eu-list-of-non-cooperative-jurisdic-tions-for-tax-purposes-anguilla-and-barbados-added-cayman-islands-and-oman-removed/>

Хүснэгт 7. Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах нийтлэг зохицуулалт болон тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлд санал авах зохицуулалтын ялгаа

Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл		Тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөл
Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах	Хуульд өөрөөр заагаагүй бол УИХ-д өргөн мэдүүлэхээс өмнө <sup>34</sup>	Төсвийн төсөлд жил бүрийн 8 дугаар сард, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд салбар бүрээр, <sup>35</sup> Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг 3 дугаар сард багтаан, нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд <sup>36</sup>
Цахим хуудаст байршуулах	Хууль, ОУ-ын гэрээнд өөрөөр заагаагүй бол 15-с доошгүй хоног санал авах ба хугацааг тодорхой зааж байршуулах <sup>37</sup>	Байнгын ажиллагаатай санал авах цахим хуудас, шуурхай утас ажиллуулах <sup>38</sup>
Тухайлсан байгууллагаас санал авах	Хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллага, мөн эрхлэх асуудалд нь хамаарах УИХ-аас байгуулдаг байгууллагаас санал бичгээр авна. <sup>39</sup>	Иргэд, иргэний нийгмийн байгууллага, Ерөнхий сайдын дэргэдэх зөвлөл, Төрийн аудитын байгууллага болон хэлэлцүүлгийн асуудалтай холбоотой салбарын асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын удирдах албан тушаалтан, санхүү, төсвийн асуудал хариуцсан холбогдох албан тушаалтныг оролцуулсан байх <sup>40</sup>

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4-т худалдаа, хөрөнгө оруулалт, татвар зэрэг бизнесийн орчинд нөлөөлөх хууль тогтоомжийн төслийг баримт бичгийн хамт албан ёсны цахим хуудас болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд 60 хоногоос доошгүй хугацаанд байршуулж, олон нийтээс санал авахаар тухайлан зохицуулсан байна. Гэтэл Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуультай хамт дараах хуулийн төслийг шууд боловсруулж, өргөн мэдүүлсэн бөгөөд эдгээр нь:

- Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай
- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Хувь хүний орлогын алан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл зэрэг болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-12.1.6 дахь хэсэгт заасан аргачлал хамаарахгүй шууд боловсруулж, батлах хууль

<sup>34</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэг  
<sup>35</sup> Төсвийн тухай хуулийн 28<sup>1</sup> дугаар зүйлийн 28<sup>1.1</sup> дэх заалт, 28<sup>1.2</sup> дахь хэсгүүд (Энэ заалтыг 2023.07.07-ны өдрийн хуулиар нэмсэн ба 2024.01.01-ээс хүчин төгөлдөр үйлчилнэ.)  
<sup>36</sup> Төсвийн тухай хуулийн 28<sup>1</sup> дугаар зүйлийн 28<sup>1.1.2</sup> дахь заалт, 28<sup>1.4</sup> дэх хэсгүүд (Энэ заалтыг 2023.07.07-ны өдрийн хуулиар нэмсэн ба 2024.01.01-ээс хүчин төгөлдөр үйлчилнэ.)  
<sup>37</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2, 38.3 дахь хэсгүүд  
<sup>38</sup> Төсвийн тухай хуулийн 28<sup>1</sup> дугаар зүйлийн 28<sup>1.1.2</sup> дахь заалт (Энэ заалтыг 2023.07.07-ны өдрийн хуулиар нэмсэн ба 2024.01.01-ээс хүчин төгөлдөр үйлчилнэ.)  
<sup>39</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, 39.3 дахь хэсгүүд  
<sup>40</sup> Төсвийн тухай хуулийн 28<sup>1</sup> дугаар зүйлийн 28<sup>1.2.1</sup> дэх заалт (Энэ заалтыг 2023.07.07-ны өдрийн хуулиар нэмсэн ба 2024.01.01-ээс хүчин төгөлдөр үйлчилнэ.)



тогтоомжийн төслийн жагсаалтад багтаагүй, мөн Төсвийн тухай хуульд тухайн жилийн төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлэхээр заасан хуульд хамаарахгүй хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 38, 39 дүгээр зүйлд заасан олон нийтээр хэлэлцүүлж, санал авах нийтлэг журмаар хэлэлцүүлэх ёстой.

## ДҮГНЭЛТ

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тухайн хуулийн хэрэгжилт, үр дагаврыг үнэлэх замаар тогтоох бол анхдагч хууль болон шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахад хэрэгцээ шаардлагын тандан судалгааг заавал хийсэн байх ёстой. Харин тухайн жилийн төсвийн тухай хуулийн хамт өргөн мэдүүлэх хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуулиар тогтоосон дээрх шаардлага хамаарахгүй. Учир нь энэ тохиолдолд Хууль тогтоомжийн тухай хууль бус Төсвийн тухай хуулиар тогтоосон журмыг баримтлах учиртай.

Гэвч сүүлийн жилүүдэд төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн тоо нэмэгдэж байгаагийн сацуу зарим тохиолдолд агуулга, зохицуулалтын хувьд заавал төсвийн хуультай хамтатган батлах шаардлагагүй хуулиудыг ч дагалдуулан батлах явдал гарах болов. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болон Хууль тогтоомжийн тухай хуулиар тогтоосон хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд тавих нийтлэг шаардлага болох олон нийтийн оролцоог хангах, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх шаардлагад нийцэхгүй байна.

Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд олон нийтээс санал авахаар тухайлан зохицуулсан худалдаа, хөрөнгө оруулалт, татвар зэрэг бизнесийн орчинд нөлөөлөх хуулийн төслийг тухайн жилийн төслийн тухай хуультай хамт өргөн мэдүүлж, Төсвийн тухай хуульд заасан журмаар хэлэлцэх, батлах нь дурдсан зохицуулалтад нийцэхгүй байгаа болно.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 21 хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг шинжлэн үзэхэд төсвийн хуулийг дагалдуулан батлах шаардлагагүй болох нь дараах үндэслэлээр тогтоогдож байна.

- Тухайн жилийн төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэх хуулийн төсөлд Төсвийн тухай хуулиар “төсвийн төсөлтэй холбоотой”<sup>41</sup> байх шаардлага тавигдах төдийгүй Хууль тогтоомжийн тухай хуулиар тогтоосон дагалдах хуулийн төсөлд тавих шаардлагыг авч үзвэл “тухайн хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бөгөөд анхдагч хуулийн үзэл баримтлал, хэлбэр, агуулгад нийцсэн байх, анхдагч хуулиар зохицуулах харилцаанд үл хамаарах хуульд өөрчлөлт оруулахгүй байх”<sup>42</sup> агуулгатай байна. Харин дээр дурдсан 21 хуулийн төслийн хувьд чухам ямар үндэслэлээр төсвийн тухай хуультай хамт батлах шаардлагатай болох нь тодорхойгүй байна.
- Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан судалгаа, үнэлгээ хийх шаардлагагүй тохиолдолд дээрх 21 хууль багтаагүй болно.

<sup>41</sup> Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.20. “төсвийн төсөлтэй холбогдуулан шийдвэрлүүлэх хууль тогтоомжийн төсөл”.

<sup>42</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3. “Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна”.  
Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 “тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх”.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн 21 хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн бүрдэл баримт бичиг буюу Үзэл баримтлал, танилцуулга нь Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох зохицуулалтад нийцэхгүй байна. Үүнд:

- **Хуулийн төслийн үзэл баримтлал:** Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн үзэл баримтлалд дагалдах хуулийн төслийн үзэл баримтлалыг тусгаагүй нь агуулгын хувьд Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын нэгдүгээр бүлгийн 3.5.3-д заасан хуулийн төсөлтэй уялдуулан нийцүүлэх зорилгоор ямар хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, ямар хуулийг хүчингүй болгох шаардлагатай байгааг судалж, хуулийг нэрээр нь тодорхой заана гэсэн шаардлагыг хангахгүй байна.
- **Хуулийн төслийн танилцуулга:** Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 21 хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгад 1) тухайн хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрийн үндэслэл, шаардлагыг тусгаагүй; 2) тухай хуулийн төслийн гол өөрчлөлтийг хэрхэн ойлгох, хэрэглэх тайлбар тусгаж бэлдээгүй. Энэ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан хуулийн төслийн танилцуулгын агуулга, Хууль тогтоомжийн

төсөл боловсруулах аргачлалын хоёрдугаар бүлгийн 7-д тусгасан хуулийн төслийн танилцуулга боловсруулах шаардлагад нийцэхгүй байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн дагалдах хуулийн дотор худалдаа, хөрөнгө оруулалт, татвар зэрэг бизнесийн орчинд нөлөө бүхий 6 хуулийн төсөл багтжээ. Эдгээр хуулийн хувьд Хууль тогтоомжийн тухай хуулиар тусгайлан тогтоосон олон нийтээр хэлэлцүүлэх шаардлагыг заавал баримтлах учиртай. Иймд эдгээр хуулийн төслийг төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлж, Төсвийн тухай хуульд заасан горимоор хэлэлцэн батлах нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд нийцэхгүй юм.

Эцэст нь дүгнэхэд, Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэгдсэн 21 хуулийн төсөл нь бүхэлдээ Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан судалгаа шинжилгээ шаардахгүй хууль тогтоомжийн жагсаалтад хамаарахгүй, мөн Төсвийн тухай хуульд заасан тухайн жилийн төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлэх хуулийн хүрээнд багтахгүй байна.

Иймд эдгээр хуулиудын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 38, 39 дүгээр зүйлд заасан олон нийтээр хэлэлцүүлж, санал авах нийтлэг журмыг баримтлан хэлэлцүүлэх ёстой байжээ.

### Хууль (Үсгийн дарааллаар)

1. Монгол Улсын Үндсэн хууль (1991);  
Монгол Улсын Их Хурлын тухай хууль (2020);
2. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль (2017);
3. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль (2018);
4. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль (2019);
5. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль (2020);
6. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль (2021);
7. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль (2022);
8. Хууль тогтоомжийн тухай хууль (2015);
9. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль (2017);
10. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2020);
11. Хууль тогтоомжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль (2020);
12. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2023);
13. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль (2022);
14. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль (2022);
15. Төсвийн тухай хууль (2011);
16. Төрийн хэмнэлтийн тухай хууль (2022);

### Журам, захирамж, тогтоол (Үсгийн дарааллаар)

1. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал (Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт);

2. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал (Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт);
3. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал (Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт);
4. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал (Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт);
5. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх аргачлал (Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт);
6. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал (Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт);
7. Нийслэл Улаанбаатар хотод гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, Нийслэл хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай (Засгийн газрын 2023 оны 294 дүгээр тогтоол);

### Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн баримт бичиг (Он цагийн дарааллаар)

1. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 9 дүгээр сарын 26-ний өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэлийн хэсэг;
2. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн “Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай” ЗГ-1/129 дугаартай албан бичиг;
3. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн “Хуулийн төсөл өргөн мэдүүлэх хугацааг товлох тухай” ХЭГ/2094 дугаартай албан бичиг;

4. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 1/5021 дугаартай албан бичиг;
5. Монгол Улсын Шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” албан бичиг;
6. Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 01/7204 дугаартай албан бичиг;
7. Монгол Улсын Сангийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтран баталгаажуулсан Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал;
8. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
9. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
10. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
11. Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
12. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
13. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
14. Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
15. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
16. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
17. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
18. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
19. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
20. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
21. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
22. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
23. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
24. Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
25. Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
26. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
27. Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
28. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүний танилцуулга;
29. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, түүний танилцуулга;

30. Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, түүний танилцуулга;
31. Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, түүний танилцуулга;
32. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, түүний танилцуулга;
33. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, түүний танилцуулга;
34. Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, хавсралт тэдгээрийн танилцуулга;
35. Засгийн газарт чиглэл өгөх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, түүний танилцуулга;

#### **Төрийн мэдээлэл эмхэтгэлийн дугаар (Он цагийн дарааллаар)**

1. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2017 он, №16
2. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2017 он, №20
3. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2017 он, №46/1003/
4. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2018 он, №44/1049/
5. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2019 он, №47/1100/
6. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2020 он, №34/1136/
7. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2020 он, №47/1149/
8. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2021 он, №29/1179/
9. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2021 он, №45/1195/

10. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2022 он, №04/1202/
11. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2022 он, №19/1217/
12. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2022 он, №47/1245/
13. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2023 он, №25/1273/

#### **Вэбсайт**

1. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
2. [www.d.parliament.mn](http://www.d.parliament.mn)
3. [www.legaldata.mn](http://www.legaldata.mn)
4. [www.forum.mn](http://www.forum.mn)
5. [www.oecd.org](http://www.oecd.org)
6. [www.consilium.europa.eu](http://www.consilium.europa.eu)

#### **Бусад эх сурвалж (Он цагийн дарааллаар)**

1. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн төслийн үзэл баримтлал (шинэчилсэн найруулга)
2. С.Оюунтуяа “Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилт /Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн жишээ дээр авч үзэх нь/” үнэлгээний судалгааны тайлан, Нээлттэй нийгэм форум, УБ 2022 он
3. Б.Баялагмаа нар “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх үе шатанд ийсэн дүн шинжилгээ” Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийн судалгааны тайлан, Нээлттэй нийгэм форум, УБ 2022 он

## ХАВСРАЛТ 1 - МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ ХАМТ БАТАЛСАН ХУУЛЬ, МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛУУД

Монгол Улсын  
2018 оны төсвийн  
тухай хууль<sup>43</sup>  
(Төрийн мэдээлэл  
эмхэтгэл 2017 он,  
№46/1003/)

### Шинээр баталсан хуулиуд

1. Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль
2. Эрүүл мэндийн даатгалын 2018 оны төсвийн тухай хууль

### Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

### Тогтоол

1. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 69 дүгээр тогтоол

## ХАВСРАЛТ 2 - МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ ХАМТ БАТАЛСАН ХУУЛЬ, МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛУУД

Монгол Улсын  
2019 оны төсвийн  
тухай хууль<sup>44</sup>  
(Төрийн мэдээлэл  
эмхэтгэл 2018 он,  
№44/1049/)

### Шинээр баталсан хуулиуд

1. Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хууль
2. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хууль

### Хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд

1. Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль

### Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд

1. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
2. Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

### Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
2. Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
4. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
5. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

### Тогтоол

1. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их хурлын тогтоолын зарим дэд заалт хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Их Хурлын 79-р тогтоол
2. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 80-р тогтоол

<sup>43</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл 2017 он, №46/1003/, <https://www.parliament.mn/nn/1582/>

<sup>44</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл 2018 он, №44/1049/, <https://www.parliament.mn/nn/4078/>

## ХАВСРАЛТ 3 - МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ ХАМТ БАТАЛСАН ХУУЛЬ, МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛУУД

Монгол Улсын  
2020 оны төсвийн  
тухай хууль<sup>45</sup>  
(Төрийн мэдээлэл  
эмхэтгэл 2019 он,  
№47/1100/)

### Шинээр баталсан хуулиуд

1. Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хууль
2. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хууль
3. Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хууль

### Хууль болон хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиуд

1. Газрын төлбөрийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль
2. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шитгэлийг нөхөн тооцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль
3. Жолоочийн даатгалын тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай хууль

### Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд

1. Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
2. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
4. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
5. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
6. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

### Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
2. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

### Тогтоол

1. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 89-р тогтоол

Монгол Улсын  
2020 оны төсвийн  
тухай хуульд  
өөрчлөлт оруулах  
тухай<sup>46</sup>  
(Төрийн мэдээлэл  
эмхэтгэл 2020 он,  
№34/1136/)

### Шинээр баталсан хуулиуд

1. Төсвийн зарим тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх, мөрдөх хугацааг хойшлуулах тухай хууль
2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хууль
3. Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль
4. Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль
5. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль

<sup>45</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл 2019 он, №47/1100/, <https://www.parliament.mn/nn/9681/>

<sup>46</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл 2020 он, №34/1136/, <https://www.parliament.mn/nn/11048/>

---

### **Хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд**

1. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль
2. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль
3. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль
4. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд
5. Монгол Улсын Засгийн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
6. Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
7. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
8. Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
9. Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд
10. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
11. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
12. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
13. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
14. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
15. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
16. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
17. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
18. Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
19. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

### **Тогтоол**

1. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын 22-р тогтоол
-



## ХАВСРАЛТ 4 - МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ ХАМТ БАТАЛСАН ХУУЛЬ, МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛУУД

Монгол Улсын  
2021 оны төсвийн  
тухай хууль<sup>47</sup>  
(Төрийн мэдээлэл  
эмхэтгэл 2020 он,  
№47/1149)

### Шинээр баталсан хуулиуд

1. Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
2. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
3. Малын тоо толгойн албан татварын тухай хууль

### Хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиуд

1. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай

### Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд

1. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
2. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
4. Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

### Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
2. Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын  
2021 оны төсвийн  
тухай хуульд  
өөрчлөлт оруулах  
тухай хууль<sup>48</sup>  
(Төрийн мэдээлэл  
эмхэтгэл 2021 он,  
№29/1179)

### Хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль

1. Төсвийн зарим тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх, мөрдөх хугацааг хойшлуулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль

### Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд

1. Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
2. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

### Тогтоол

1. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын 69-р тогтоол
2. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын 70-р тогтоол
3. Үндсэн хуулийн цэцийн гишүүний албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын 71-р тогтоол
4. Прокурорын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын 72-р тогтоол
5. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын 73-р тогтоол

<sup>47</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл 2020 он, №47/1149/, <https://www.parliament.mn/nn/12522/>

<sup>48</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл 2021 он, №29/1179/, <https://www.parliament.mn/nn/15149/>

## ХАВСРАЛТ 5 - МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ ХАМТ БАТАЛСАН ХУУЛЬ, МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛУУД

Монгол Улсын  
2022 оны төсвийн  
тухай хууль<sup>49</sup>  
(Төрийн мэдээлэл  
эмхэтгэл 2021 он,  
№45/1195/)

### Шинээр баталсан хуулиуд

1. Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хууль
2. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хууль
3. Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хууль
4. Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль

### Хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиуд

1. Нийгмийн халамжийн тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай хууль

### Хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд

1. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль
2. Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль
3. Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль

### Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд

1. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
2. Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3. Монгол Улсын Хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
4. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
5. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
6. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
7. Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
8. Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
9. Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

### Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
2. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
4. Ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
5. Тэсэрч дэлбэрэх бодит, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
6. Химийн хорт болон аюулгүй бодисын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
7. Органик хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
8. Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
9. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

<sup>49</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл 2021 он, №45/1195/, <https://www.parliament.mn/nn/15559/>

10. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
11. Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
12. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
13. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

#### **Тогтоол**

1. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын 84-р тогтоол
2. Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай МОНгол Улсын Их Хурлын 85-р тогтоол
3. Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай Монгол Улсын Их Хурлын 87-р тогтоол
4. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 87-р тогтоол

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль<sup>50</sup>  
(Төрийн мэдээлэл эмхэтгэл 2022 он, №04/1202/)

#### **Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд**

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
2. Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилсан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль<sup>51</sup>  
(Төрийн мэдээлэл эмхэтгэл 2022 он, №19/1217/)

#### **Шинээр баталсан хуулиуд**

1. Төрийн хэмнэлийн тухай хууль
2. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль
3. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль
4. Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль

#### **Хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд**

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль

#### **Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

#### **Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд**

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
2. Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

<sup>50</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл 2022 он, №04/1202/, <https://www.parliament.mn/nn/16144/>

<sup>51</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл 2021 он, №45/1195/, <https://www.parliament.mn/nn/15559/>

3. Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
4. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
5. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
6. Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
7. Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

#### **Тогтоол**

1. Төрийн өмчит хуулийн этгээдийг хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 16-р тогтоол
2. Хүүхдийн цэцэрлэгчийн хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 17-р тогтоол

## **ХАВСРАЛТ 6 - МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ, МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ, ЭДГЭЭР ХУУЛЬТАЙ ХАМТ БАТАЛСАН ХУУЛЬ, МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛУУД**

Монгол Улсын  
2023 оны төсвийн  
тухай хууль<sup>52</sup>  
(Төрийн мэдээлэл  
эмхэтгэл 2022 он,  
№47/1245/)

#### **Шинээр баталсан хуулиуд**

1. Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хууль
2. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хууль
3. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль
4. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль
5. Гаалийн албан татварын хөнгөлөх тухай хууль
6. Засгийн газар дах хяналтын тухай хууль

#### **Хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулиуд**

1. Аялал жуулчлалын тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хууль
2. Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай хууль
3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай

#### **Хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд**

1. Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хууль
2. Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль
3. Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль
4. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль

#### **Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд**

1. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
2. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
4. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

<sup>52</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл 2022 он, №19 /1217/, <https://www.parliament.mn/nn/17656/>

- 
5. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
  6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
  7. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
  8. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
  9. Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
  10. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
  11. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль
  12. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
  13. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

### **Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд**

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  2. Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  4. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  5. Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  6. Усны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  7. Хог хаягдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  8. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  9. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  10. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  11. Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  12. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  13. Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  14. Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  15. Орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  16. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  17. Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  18. Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  19. Авто тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  20. Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  21. Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
-

- 
22. Хэмжил зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  23. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  24. Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  25. Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  26. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  27. Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  28. Органик хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  29. Нялх балчир хүүхдийн хүнсний түүхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  30. Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  31. Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  32. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  33. Мал амьтны эрүү мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  34. Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  35. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  36. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  37. Ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  38. Таримал ургамлын үр, сортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  39. Усны нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  40. Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  41. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  42. Дархлаажуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  43. Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  44. Согтууруулах унтаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  45. Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  46. Эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  47. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  48. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  49. Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  50. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  51. Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  52. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  53. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  54. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
-

- 
55. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  56. Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  57. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  58. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  59. Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  60. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  61. Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  62. Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  63. Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  64. Музейн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  65. Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  66. Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  67. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  68. Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  69. Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  70. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  71. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  72. Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  73. Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  74. Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  75. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  76. Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  77. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  78. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  79. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
  80. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

### **Тогтоол**

1. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 65-р тогтоол
2. Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай тухай Монгол Улсын Их Хурлын 67-р тогтоол
3. Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай тухай Монгол Улсын Их Хурлын 68-р тогтоол
4. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тухай Монгол Улсын Их Хурлын 69-р тогтоол
5. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай тухай Монгол Улсын Их Хурлын 70-р тогтоол
6. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээний тухай тухай Монгол Улсын Их Хурлын 71-р тогтоол
7. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай тухай Монгол Улсын Их Хурлын 72-р тогтоол

Монгол Улсын  
2023 оны төсвийн  
тухай хуульд  
өөрчлөлт оруулах  
тухай<sup>53</sup>

(Төрийн мэдээлэл  
эмхэтгэл 2023 он,  
№25/1273/)

#### **Хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль
2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль

#### **Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд**

1. Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
2. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

#### **Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд**

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
2. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль
4. Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
5. Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

#### **Тогтоол**

1. Тогтоолын төсөл буцаах тухай Монгол Улсын Их Хурлын 43-р тогтоол
2. Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын 45-р тогтоол
3. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын 46-р тогтоол
4. Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 48-р тогтоол

<sup>53</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл 2023 он, №25/1273/, <https://www.parliament.mn/nn/30711/>